

## **Говьсүмбэр аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн “Шилэн дансны тухай хууль” –ийн хэрэгжилтийн 2015 оны эхний хагас жилийн тайлан**

2014 онд Шилэн дансны тухай батлагдан гарч мөрдөгдөх болсонтой ходбогдуулан дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Хэлтсийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд болон мэргэжилтэн, нягтлан бодогчийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх заалт оруулан ажиллаж байна.
- 2015 онд Шилэн дансны тухай хуульд заасны дагуу шилэн дансанд байршуулах мэдээллүүдийг судлан, графикчилсан төлөвлөгөө боловсруулж, хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна.
- Хэлтсийн цахим хуудсанд “Шилэн данс” хуудас нээлгэж шилэн дансны вэбтэй холболт хийсэн.
- 2015 онд батлагдсан төсвийн хуваарийг хугацаанд нь шивж оруулан файл хэлбэрээр давхар байршуулсан.
- 1, 2, 3, 4, 5 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийг мэдээ, авлага, өглөгийн дэлгэрэнгүй мэдээг хуулийн хугацаанд үнэн зөв шивж, файл хэлбэрээр баталгаажуулсан мэдээг давхар оруулсан.
- 2014 оны жилийн эцсийн Санхүүгийн тайлан, Аудитын дүгнэлтийг файл хэлбэрээр байршуулан ажилласан.
- Бусад мэдээллүүдийг хуулийн хугацааны дагуу маягт бүрээр гүйлгээ гараагүй болон байгууллагад хамааралгүй тохиолдолд тайлбар утгуудыг оруулж өглөө.
- Дээрх төсвийн мэдээллүүдээ шилэн дансны вэбд байршуулахаас гадна байгууллагын ил тод байдлын самбарт хэвлэмэл байдлаар, хэлтсийн цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдлын цэсэнд тухай бүр файл хэлбэрээр /2014 оны санхүүгийн тайлан, Аудитын дүгнэлт, Аудитын зөвлөмжийн биелэлт, батлагдсан төсөв, сар бүрийн төсвийн мэдээ, өглөг авлагын дэлгэрэнгүй мэдээ, шилэн дансны графикчилсан төлөвлөгөө, бичиг хэрэг, тээвэр шатахууны худалдан авалт/-ыг байршуулан ажиллаж байна.

**2014 оны санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлтэнд:** “Статистикийн хэлтэс нь Шилэн дансны тухай хууль, журмыг мөрдөн ажиллаж мэдээлэл байршуулах хугацааг нарийн тусгаж өгсөн төлөвлөгөө боловсруулан хэлтсийн даргаар батлан хэрэгжүүлсэн байна. Шилэн дансны мэдээллийг <http://www.shilendans.gov.mn/main/agency/762> сайтад болон <http://govisumber.nso.mn/> гэсэн байгууллагын сайтанд давхар байршуулж мөн хэлтсийн санхүүгийн ил тод байдлын самбарт хэвлэмэл байдлаар байршуулан ажилласан байна” гэж тусгажээ.

2015 оны Байгууллагын ил тод байдлыг ханган ажиллах ажлын төлөвлөгөөнд Шилэн дансны хэрэгжилтийн ажлыг давхар тусган өгч ажиллаж байна.

Хэрэгжилтийг тайлагнасан: Нягтлан бодогч

/С.Эрдэнэзаяа/